

САЙДЫН ТУШААЛ

2025 оны ... дугаар сарын ...  
-ны өдөр ...

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг 1 дүгээр, төсвийн тодотголын хүснэгтийг 2 дугаар, төсвийн тодотголын нэгдсэн хүснэгтийг 3 дугаар, жилийн төсөв батлах хүснэгтийг 4 дүгээр, жилийн төлөвлөгөө батлах хүснэгтийг 5 дугаар, сарын ажлын гүйцэтгэлийн хүснэгтийг 6 дугаар, ажлын гүйцэтгэл, зардлын тайлан гаргах хүснэгтийг 7 дугаар, санхүүжилтийн хуваарь гаргах хүснэгтийг 8 дугаар, сарын ажлын гүйцэтгэл нэгтгэх хүснэгтийг 9 дүгээр, шинээр эхлэх төслүүдийн жагсаалт нэгтгэх хүснэгтийг 10 дугаар, архивт тайлан, материал хүлээн авсан мэдэгдлийн загварыг 11 дүгээр, гүйцэтгэсэн ажлын төсвийн нэгтгэлийн хүснэгтийг 12 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал болон "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар)-д үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үндэсний геологийн алба (П.Батцацрал)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар)-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг баталсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.ТУВААН

## Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлд заасан улсын төсвийн хөрөнгө (цаашид "УТХ" гэх)-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажил (цаашид "ГСА" гэх)-ыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам нь Захиргааны ерөнхий хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

1.3. УТХ-өөр гүйцэтгэх ГСА-д геологи, геофизик, геохими, гидрогеологи, тектоник, геоэкологи, гео-гамшиг, гео-орчин, хот суурингийн геологи, инженер геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуул хийх, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, металлогени, минерагений судалгаа хийж, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах зэргийг хамруулж ойлгоно.

1.4. ГСА-д улсын төсвөөс зарцуулах төсвийн ерөнхийлөн захирагч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (цаашид "сайд" гэх), сайдаас эрх шилжүүлэх шийдвэрийн дагуу төсвийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсвийн шууд захирагч нь геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "ҮГА" гэх)-ын дарга (цаашид "ҮГА-ны дарга" гэх) байна.

### Хоёр. Санхүүжүүлэх

2.1. Геологийн судалгааны ажлын төсөл, төсөвт тодотгол хийх

2.1.1. ГСА-ын төсөл гүйцэтгэгч (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь өмнөх жилийн хээрийн судалгааны ажлын үр дүнд үндэслэн, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, эдийн засгийн хямрал, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, санхүүжилтийн хоцрогдол зэрэг шалтгааны улмаас төсөл, төсөвт тодотгол хийх саналаа жил бүрийн 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ҮГА-нд албан бичгээр хүргүүлэх бөгөөд саналд дор дурдсан нөхцөлүүдийг тодорхой тусгасан байна.

2.1.1.а/. Ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.1.1.б/. ГСА гүйцэтгэх явцад болон үр дүнгээс хамаарч арга, аргачлалыг солих, ажлын хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.1.1.в/. ГСА-ын тухайн жилийн магадалшгүй ажлын зардлыг ашиглах.

2.1.1.г/. Гаднын байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын нэгж өртгийн өөрчлөлтөөс хамаарсан үнээр гэрээний төсөвт тохируулга оруулах

2.1.2. Гүйцэтгэгч нь тухайн жилийн ГСА-ын төсөл, төсвийн тодотгол болон зарчмын зөрүүтэй, шийдвэрлүүлэх асуудлын саналыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (цаашид "ЭБМЗ" гэх)-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхдээ 2, 3 дугаар хавсралтын дагуу боловсруулан энэ журмын 2.1.1-д заасан хугацаанд ҮГА-нд ирүүлэх бөгөөд саналд дор дурдсан мэдээллийг ирүүлнэ.

2.1.2.а/. Төсөл гүйцэтгэх хугацаанд хийсэн ажлын үр дүн, хэмжээ, гүйцэтгэл, төсвийн дүн;

2.1.2.б/.гаднын байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын хэмжээ, гүйцэтгэл, үнийн өөрчлөлт, төсвийн дүн;

2.1.2.в/.илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын хэмжээ, төсвийн дүнг жил бүрээр гаргаж;

2.1.2.г/.өөрийн хүчээр гүйцэтгэсэн ажлын санхүүжилт аваагүй гүйцэтгэлийг дараа оны ГСА-ын төсөв, төлөвлөгөөнд тусгуулах санал.

2.1.3.ҮГА нь ГСА-ын арга, аргачлал, хэмжээ, төсөвт оруулах өөрчлөлтийн саналыг жил бүрийн 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор хянаж 3 дугаар сарын 31- ны өдрийн дотор ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулсан байна.

2.1.4.ҮГА-ны дарга нь ЭБМЗ-өөс гаргасан дүгнэлтийг үндэслэн төсөл тус бүрийн ажлын арга, аргачлал, хэмжээ, төсвийн тодотголыг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор шийдвэрлэсэн байна.

2.1.5.ҮГА нь үргэлжлэн хэрэгжиж байгаа ГСА-ын гүйцэтгэгчээс ирүүлсэн тухайн жилийн төсвийн тодотголд үнийн тохируулга оруулах саналыг үндэслэлтэй гэж үзвэл геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "яам" гэх)-ын санхүүгийн асуудал хариуцсан нэгжид танилцуулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "Сангийн яам" гэх)-д уламжлан шийдвэрлүүлнэ.

2.1.6.ГСА-ын тухайн жилийн төсөвт батлагдсан магадалшгүй ажлын зардлыг зарцуулах асуудлыг хээрийн ажлын явцад шинээр тогтоосон баримтад үндэслэсэн гаргасан гүйцэтгэгчийн саналд үндэслэн шуурхай хяналтын комисс газар дээр нь шийдвэрлэнэ. Комисс нь энэ тухай илтгэх хуудаст тэмдэглэж ҮГА-д танилцуулна.

2.1.7.ҮГА нь үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийн тухайн онд батлагдсан төсвийн тодотгол, шинээр гүйцэтгэх төслүүдийн тухайн оны гэрээнд тусгагдсан төсвийн дүнг 4, 5 дугаар хавсралтын дагуу нэгтгэсэн төсөв, төлөвлөгөөний тодотголын санал, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий танилцуулга, ЭБМЗ-ийн дүгнэлт, ҮГА-ны даргын шийдвэр, шинээр эхэлсэн төслүүдийн гэрээ (эх хувь)-ний хамт 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулж, сайдаар батлуулан Сангийн яаманд хүргүүлнэ.

2.1.8.ҮГА нь тухайн жилийн ГСА-ын суурин боловсруулалт болон хээрийн ажил дуусгавар болсны дараа гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлт, шуурхай хяналтын тэмдэглэл, хээрийн ажил хүлээн авсан тэмдэглэл, холбогдох нотлох баримтыг үндэслэн төсөлд тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, төсвийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор нэгтгэнэ.

2.1.9.ҮГА нь сайдын төсвийн багцад батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрийг ГСА-д бүрэн зарцуулахын тулд төслүүдийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг тухайн онд багтаан гүйцэтгэгч нарт олгох саналаа энэ журмын 4, 5 дугаар хавсралтын дагуу боловсруулан, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий танилцуулга болон холбогдох нотлох баримтын хамт яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хянуулж, сайдаар батлуулан Сангийн яаманд хүргүүлнэ.

2.1.10. Гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас төслийн гүйцэтгэлд саатал гарсан тохиолдолд нэн даруй ҮГА-нд албан бичгээр мэдэгдэнэ.

2.1.11.ГСА гүйцэтгэх гэрээний хугацааг гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн, мөн урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөлийн улмаас санхүүжилт 90 хоногоос илүү хугацаагаар хоцорсон тохиолдолд гүйцэтгэгч талын санал, нотлох баримтыг үндэслэн ҮГА-ны даргын шийдвэрээр сунгаж болох бөгөөд сунгасан шийдвэрийг яамны геологийн асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ.

## 2.2. Геологийн судалгааны ажлын гүйцэтгэл гаргах, тайлагнах

2.2.1. Гүйцэтгэгч нь тухайн жилийн төсөв батлагдсаны дараа төсөл тус бүрийн сарын ажлын гүйцэтгэлийг 6 дугаар хавсралтын дагуу үнэн зөв, алдаа, засваргүй үйлдэж цахимаар илгээх ба сар бүрийн 20-ны өдрийн дотор албан бичгээр 3 хувийг УГА-нд хүргүүлнэ.

2.2.2. Энэ журмын 2.2.1-д заасан гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй болохыг тухайн ГСА гүйцэтгэгч хариуцах бөгөөд ажлын гүйцэтгэлийг худал мэдүүлж санхүүжилт авсан нь тодорхой баримт, нотолгоогоор тогтоогдвол холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага тооцно.

2.2.3. Гүйцэтгэгч нь жил бүрийн ГСА-ын гүйцэтгэл, түүний зардлын задаргааг ажлын нэр төрөл бүрээр 7 дугаар хавсралтын дагуу гаргаж ГСА-ын эхний хагас жил (6 дугаар сарын 20-ны өдрийн дотор) болон жилийн эцсийн тайлан (12 дугаар сарын 20-ны өдрийн дотор)-д хавсарган УГА-нд тайлагнана.

2.2.4. ГСА-ын төсвийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг шалгаруулах үйл ажиллагаанд яамны аудитын асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөт хяналтыг жилд нэг удаа хийж, сайдад дүгнэлт, санал, зөвлөмжийг танилцуулна.

## 2.3. Геологийн судалгааны ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх

2.3.1. УГА нь төсөл тус бүрээр ажил гүйцэтгэх гэрээний дагуу санхүүжилтийн хуваарийг 8 дугаар хавсралтын дагуу боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор яамны санхүүгийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Тус нэгж нь төлөвлөгөөт онд сайдын багцад батлагдсан салбарын хэмжээний санхүүжилтийн хуваарьт нэгтгэн Сангийн яаманд 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.3.2. УГА нь журмын 2.2.1-д заасны дагуу гүйцэтгэгчээс ирүүлсэн сар бүрийн ажлын гүйцэтгэлийг хянаж, 9 дүгээр хавсралтын дагуу нэгтгэнэ. Гүйцэтгэлийн нэгтгэлийг 3 хувь үйлдэн УГА-ны даргаар баталгаажуулж ажил гүйцэтгэх гэрээнд заасан хуваарийн дагуу тухайн сарын 25-ны өдрийн дотор санхүүжилтийн эрх нээлгэхээр Сангийн яаманд албан бичгээр хүргүүлнэ.

2.3.3. УГА нь судалгааны ажлын тасралтгүй байдлыг хангах үүднээс санхүүжилтийн эрх нээгдмэгц ГСА-ын дансаар дамжуулан гэрээнд заасан төсөл гүйцэтгэгчийн харилцах дансанд ажлын 3 өдөрт багтаан шилжүүлнэ.

2.3.4. УГА нь санхүүжилтийн эрх хязгаартай нээгдсэн тохиолдолд ямар нэгэн ашиг сонирхлын үүднээс тэгш бус хандлага гаргахгүйгээр баталгаажсан сар бүрийн гүйцэтгэлд нь хувь тэнцүүлэн тооцож ажлын 3 өдөрт багтаан олгоно.

2.3.5. Гүйцэтгэгч санхүүжилтийн дансаа сольсон тохиолдолд ажлын 3 өдрийн дотор УГА-нд албан бичгээр мэдэгдэнэ.

2.3.6. Гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон ГСА гүйцэтгэх гэрээнд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг хугацаагүй гаргаж гэрээнд хавсаргана.

2.3.7. Гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тухайн жилд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг нийт гүйцэтгэх ажилтай харьцуулсан хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлүүлэх хүсэлтээ Захиалагчид жил бүрийн 3-р сарын 01-ний өдрийн дотор гарган шийдвэрлүүлж болно.

2.3.8. Захиалагч нь гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг судлан тухайн жилд гүйцэтгэсэн ажлын хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх шийдвэрийг хүсэлт ирснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гаргаж холбогдох банканд албан бичгээр хүргүүлнэ.

2.3.9.ГСА-ын сүүлийн 1 жилд ногдох гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхгүй бөгөөд ГСА гүйцэтгэх гэрээг дүгнэсний дараа гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.

### **Гурав. Гүйцэтгэх**

3.1. Геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, даалгаврыг батлуулах

3.1.1.ГСА-ыг гүйцэтгэхэд холбогдох бодлого, хууль, тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу бүс нутгийн хөгжлийг жигд хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл бүхий орчныг бүрдүүлэх зорилгоор геологийн тогтцыг нарийвчлан судлах, давхраажсан хурдас, гүний чулуулгийг ангилах, нас тогтоох, металлогений муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг бүрхэх, газрын хэвлийн дээр болон доор барилга байгууламж барихтай холбоотой суурь бүтцийн судалгаа хийгдсэн байх, дэлхийн болон бүс нутаг, улс орны зах зээл дээр өндөр ач холбогдолтой эрдэс түүхий эдийг богино хугацаанд бага зардлаар судлан, үр дүнд хүрэх зарчмыг баримтална.

3.1.2.ҮГА нь дараа онуудад УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ыг төлөвлөхдөө холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэшсэн мэргэжилтнүүдээс саналыг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор авч нэгтгэнэ.

3.1.3.ҮГА нь энэ журмын 3.1.1-д заасан зарчмыг баримтлан дараа онуудад гүйцэтгэхээр энэ журмын 3.1.2-ын дагуу ирүүлсэн ГСА-ын саналыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөв, төлөвлөгөөний төсөл болон дунд хугацааны төлөвлөлт, төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.1.4. Яамны геологийн асуудал хариуцсан нэгж нь жил бүрийн 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дараа онуудад гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөний төсөл, төсөөллийг хянаж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон дараа оны төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төлөвлөлт, төсвийн төсөөллийн саналыг боловсруулан эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Сангийн яаманд хүргүүлнэ.

3.1.5.ҮГА нь сайдын төсвийн багц батлагдмагц төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх ГСА-ын төсөл тус бүрд хуваарилах төсвийн болон гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний санал, төсөв хуваарилсан үндэслэл бүхий танилцуулгыг жилийн бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.1.6.ҮГА нь шинээр хэрэгжүүлэх төслийн нэр, код, талбайн хэмжээ, байршил, хавтгайн дугаар, хэрэгжих хугацаа, төсөвт өртөг, тухайн жилд санхүүжүүлэх төсөв, нэгж өртөг тооцсон үндэслэлийг 10 дугаар хавсралтын дагуу боловсруулан журмын 3.1.5-д заасан саналд хавсаргана.

3.1.7.Яамны геологийн асуудал хариуцсан нэгж нь ҮГА-ны саналыг үндэслэн төлөвлөгөөт онд хэрэгжүүлэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөг 4, 5 дугаар хавсралтын дагуу боловсруулан холбогдох хуульд заасан хугацаанд багтаан батлуулж СЯ, ҮГА-нд хүргүүлнэ.

3.1.8. Яамны худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 3.1.6-д заасны дагуу ҮГА-аас ирүүлсэн саналыг яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулж сайдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, жагсаалтад нэгтгэн батлуулж холбогдох төрийн байгууллагуудад албажуулан хүргүүлнэ.

3.1.9.ҮГА нь төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх ГСА-ын геологийн даалгаврын төсөлд салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэшсэн мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэн, яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр 01 дүгээр

сарын 30-ны өдрийн дотор хянуулж 02 дугаар сарын 20-ний өдрийн дотор яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна.

### 3.2. Геологийн судалгааны ажил гүйцэтгэх

3.2.1. Гүйцэтгэгч нь ГСА-ыг батлагдсан гэрээ, геологийн даалгавар, төсөлд тусгасны дагуу холбогдох заавар, түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд орчин үеийн шинэ техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтэт арга, аргачлалыг нэвтрүүлж чанартай гүйцэтгэнэ.

3.2.2. Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх геофизик болон бусад ажлын арга аргачлалыг ҮГА-нд хянуулна. Мөн ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон сансрын зураг, урд өмнө нь тухайн төслийн талбайд хийгдсэн геологийн судалгааны ажлын тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг ҮГА-ны гео-мэдээллийн төвөөс захиалан цахим болон биет байдлаар авна.

3.2.3. Гүйцэтгэгч нь УТХ-өөр гүйцэтгэсэн ГСА-ын дээж, сорьцын шинжилгээг Олон улсын итгэмжлэлийн байгууллага, үндэсний стандарт, хэмжилзүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын аль нэгний олгосон хүчин төгөлдөр итгэмжлэл бүхий судалгааны лабораторитой болон байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

3.2.4. Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын гэрээг дүгнэж, төлбөр тооцоог бүрэн барагдуулсан баримтыг ГСА-ын үр дүнгийн тайланд хавсаргасан байна.

3.2.5. Геологийн даалгавраар өгөгдсөн асуудлуудыг судалгааны оновчтой шинэлэг арга аргачлал, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэж, онолын хувьд маргаантай байгаа асуудлыг шийдвэрлэх ач холбогдол бүхий баримтыг олж тогтоосон болон ашигт малтмалын хувьд хэтийн төлөвтэй эсэхийг бүрэн эцэслэж, ирээдүйд орд болох боломжийг тогтоож, тайланг хугацаанд нь онцсайн хамгаалсан гүйцэтгэгчийг төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 1 хүртэл хувиар урамшуулан шагнаж болно. Шагналын хувь, хэмжээг ЭБМЗ-ийн хурлын дүгнэлтийг үндэслэн сайдын шийдвэрээр олгоно.

3.2.6. Гүйцэтгэгч нь ҮГА-аас баталсан маягтын дагуу төсөл тус бүрээр геологийн даалгаврын биелэлтийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор ҮГА-нд цахим болон цаасан хувиар албажуулан хүргүүлнэ.

3.2.7. ҮГА нь ГСА-ын улирлын тайланг нэгтгэн улирал бүрийн дараа сарын 5-ны өдрийн дотор яамны геологийн асуудал хариуцсан нэгжид цахим болон цаасан хувиар албажуулан хүргүүлнэ.

3.2.8. ҮГА-ны дарга нь ГСА-ын төсөл тус бүрийн суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах үүрэг бүхий комиссыг томилон ажиллуулна.

3.2.8.1. Комиссын бүрэлдэхүүнд яамны геологийн асуудал хариуцсан нэгжийн албан хаагчдыг удирдлагатай нь зөвшилцсөний дагуу оролцуулж болно.

3.2.8.2. Комиссын бүрэлдэхүүнд ГСА-ын туршлага солилцох үндэслэлээр төслүүдийн бүрэлдэхүүнээс геологичдыг оролцуулж болно.

3.2.8.3. Комиссын бүрэлдэхүүнд салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийг ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байхаар сонгон оролцуулж болно.

3.2.8.4. Комиссын бүрэлдэхүүн суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авахаас өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, нууцлалын баталгаатай танилцан хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна.

3.2.9. ГСА-ын захиалагчийн санал болон гүйцэтгэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн судалгааны арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх үүрэг бүхий Монголын стратиграфийн комисс (цаашид "МСК" гэх), Редакцийн зөвлөл (цаашид "РЗ" гэх)-ийн гишүүдээс бүрдсэн багийг УГА-ны дарга томилон ажиллуулж болно.

3.2.10. Ашигт малтмалын чиглэлээр аргазүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн багийг УГА-ны дарга томилон ажиллуулж болно.

3.2.11. Томилсон багийн бүрэлдэхүүнд шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулж болно.

3.2.12. Комисс нь гүйцэтгэгчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд шуурхай хяналтыг гүйцэтгэн ГСА зохих арга, аргачлал, зааврын дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалган маргаантай, хүндрэлтэй асуудлыг тухай бүр судлан мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллана.

3.2.13. Шуурхай хяналтын үед ажлын гүйцэтгэлийг газар дээр нь холбогдох баримт материал, мэдээ, мэдээлэлтэй танилцах, хэмжилт хийх замаар баталгаажуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Гүйцэтгэгч нь ГСА-тай холбоотой бүх баримт материал, мэдээ, мэдээллийг комисст саадгүй танилцуулна.

3.2.14. Комисс, МСК, РЗ-ийн гишүүд болон гүйцэтгэгч нь ГСА-ын гэрээний хэрэгжилтийн явцад шинээр тогтоогдсон ашигт малтмалын талаарх мэдээллийг хувь хүн, байгууллага, олон нийтэд дамжуулах, хэвлэн нийтлэхийг хориглох бөгөөд бусад мэдээллийг УГА-ны зөвшөөрөлтэйгөөр хэвлэн нийтэлж болно.

3.2.15. Хээрийн судалгааны үед геологийн даалгаварт тусгасан асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үед шинээр тогтоосон баримт, үр дүнг үндэслэн ажлын арга аргачлал, хэмжээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах гүйцэтгэгчийн санал нь үндэслэлтэй байгаа тохиолдолд комисс тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд асуудлыг газар дээр нь шуурхай шийдвэрлэнэ. Комисс нь энэ тухай илтгэх хуудаст дэлгэрэнгүй тусган УГА-нд хүргүүлж, танилцуулна.

3.2.16. Шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авахад ГСА-ын гэрээ, геологийн даалгавар болон арга, аргачлал зөрчсөн, хийгээгүй ажлыг гүйцэтгэлд оруулж санхүүжилт авсан нь тогтоогдвол уг ажлыг нөхөн хийлгэх, ажлын гүйцэтгэлээс хасах, ажлын биет хэмжээг холбогдох зардлын хамт санхүүжүүлэхээс татгалзах шийдвэрийг комисс газар дээр гаргаж шийдвэрлэнэ. Энэ тухай комисс нь үндэслэл, баримтаар нотлон дэлгэрэнгүйгээр илтгэх хуудаст тусган УГА-д танилцуулж, баталгаажуулна. Үүссэн зөрчил ноцтой бөгөөд төслийн ажлын эцсийн үр дүн шууд нөлөөлөхүйц хохиролтой тохиолдолд төслийн ажлыг зогсоох саналыг комиссын гишүүдийн олонхийн саналд үндэслэн гаргаж, энэ тухай УГА-нд мэдэгдэн шийдвэрлүүлнэ.

3.2.17. МСК, РЗ нь батлагдсан удирдамжийн дагуу төсөл тус бүрийн судалгааны ажилд үүссэн маргаантай болон хүндрэлтэй асуудлыг судалж, мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгч ажиллах бөгөөд шийдвэрлэсэн асуудлаа илтгэх хуудсаар УГА-нд танилцуулна.

3.2.18. Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах, судалгааны ажлын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх, хяналтын дээж, сорьц авах, түүнд лабораторийн шинжилгээ хийлгэх, ГСА-ын арга, аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, хяналтад шаардагдах техник, тоног төхөөрөмж, багаж худалдан авах, МСК, РЗ, ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал, ГСА-ыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардлыг ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас

санхүүжүүлнэ. ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас дараах нэр бүхий үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

3.2.18.1 Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах, судалгааны ажлын явцад гарсан маргаантай болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зардал, хяналтын дээж, сорьц авах, түүний лабораторийн шинжилгээний зардал,

3.2.18.2 ГСА-ын төсөв зохиох, төлөвлөх, даалгавар, арга, аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх зардал,

3.2.18.3 ГСА-тай холбоотой дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох зардал,

3.2.18.4 ГСА-ын суурин боловсруулалт, хээрийн ажлын гүйцэтгэл, явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах, хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж, багаж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл худалдан авах зардал,

3.2.18.5 МСК, РЗ, ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал,

3.2.18.6 ГСА-ыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардал,

3.2.18.7 Гео шинжлэх ухааны чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардал,

3.2.19. Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, танхим, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэргэжил, аргазүйн зөвлөлдөх хурал, зөвлөгөөнд оролцох ажлыг ГСА-ын аргачлал хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

3.2.20. Салбарын хүний нөөцийг давтан сургах ажлыг мэргэжлийн холбоод, их дээд сургууль, төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтран зохион байгуулж болно.

3.2.21.ҮГА нь гүйцэтгэгчийн сар бүрийн ажлын санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэлд тусгасан өөрийн хүчээр хийсэн, НӨАТ тооцсон ажлын 2 хувьтай тэнцэх дүнг ГСА-ын аргачлал хяналтын дансанд суутган төвлөрүүлнэ.

3.2.22.ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас энэ журмын 3.2.18, 3.2.19-д заасан зардлыг санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг ҮГА-ны дарга баталж, энэ журамд нийцүүлэн Сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүжилтийн эрхийг нээлгэн зарцуулна.

3.2.23.ҮГА нь ГСА-ын аргачлал, хяналтын зардлын санхүүжилтийн тайланг байгууллагын шилэн дансанд тогтмол байршуулж нийтэд мэдээлнэ.

3.2.24. Тухайн онд үргэлжлэх болон шинээр эхэлж байгаа ГСА хэрэгжих аймгийн Засаг даргын тамгын газар, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад төслийн ач холбогдол, үр дүнгийн талаар мэдэгдэж, гүйцэтгэгч нарт холбогдох зөвшөөрөл авах, ажиллах нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг яамны геологийн асуудал хариуцсан нэгж болон ҮГА зохион байгуулна.

3.2.25. ГСА-ын улирлын тайлан хүлээн авах маягтыг ҮГА-ны дарга батална.

3.2.26. МСК болон РЗ-ийн тухайн жилийн төлөвлөгөөг яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулсаны үндсэн дээр ҮГА-ны дарга 2 дугаар сарын 15-ны дотор батална.

3.2.27. Гүйцэтгэгч нь төслийн ахлагч, голлох мэргэжилтэн өөрчлөгдсөн тухай бүр ҮГА-д шуурхай мэдээлж баталгаажуулсан байна.

### **Дөрөв. Үр дүнг тооцох**

4.1. Геологийн судалгааны ажлын үр дүнг хүлээн авах

4.1.1. Гүйцэтгэгч нь геологийн даалгаварт заасан хугацаанд үр дүнгийн тайланг зохиож, холбогдох чиглэлээр МСК, РЗ болон ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчийн дүгнэлтийг тус тус гаргуулан, шаардлагатай засвар, нэмэлт өөрчлөлтийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр албажуулан ҮГА-д хүргүүлнэ. Ирүүлсэн тайлан болон бусад холбогдох материалтай ҮГА болон яамны асуудал хариуцсан мэргэжилтнүүдээр хянуулж шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийсний дараа ЭБМЗ-өөр хэлэлцүүлэнэ.

4.1.2. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлсэн хугацаагаар геологийн даалгаврын хугацааг дууссанд тооцно.

4.1.3. ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчид болон МСК, РЗ нь тус бүр ГСА-ын даалгавар, төсөл хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу 30 хоногт багтаан ГСА-ын үр дүнгийн тайлантай танилцаж дүгнэлт, зөвлөмж гарган, засвар, өөрчлөлт хийх саналыг гүйцэтгэгчид өгсөн байна.

4.1.4. ГСА-ын үр дүнгийн тайлантай яам болон ҮГА-ны асуудал хариуцсан ажилтнууд тус бүр ажлын 5 өдөрт багтаан танилцана.

4.1.5. ГСА-ын хамрах хүрээ, ажлын хэмжээнээс хамаарч үр дүнгийн тайланд дүгнэлт, зөвлөмж, санал гаргах хугацааг бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тус бүр ажлын 10 хүртэл өдрөөр сунгаж болно.

4.1.6. Гүйцэтгэгч нь тайланд тусгах засвар, өөрчлөлт, сайжруулалтыг ажлын 10 өдөрт багтаан хийж холбогдох тал (шинжээч, МСК, РЗ, холбогдох мэргэжилтэн)-д танилцуулсан байна.

4.1.7. Гүйцэтгэгч нь ГСА-ын үр дүнгийн тайланг зохиогч, шинжээч, МСК, РЗ-ийн төлөөллийг байлцуулан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

4.1.8. ЭБМЗ-ийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн сайд ГСА-ын үр дүнгийн тайланг хүлээн авах эсэх шийдвэр гаргана.

4.1.9. Сайдын шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг 11 дүгээр хавсралтын дагуу Геологийн баримтын төв архив (цаашид "ГБТА" гэх) хүлээн авч, ажлын 5 өдөрт багтаан холбогдох журам, зааврын дагуу бүртгэн ҮГА-ны асуудал хариуцсан нэгжид мэдэгдэнэ. Бүртгэгдэж, мэдэгдсэн, нууцад хамрагдаагүй тайлан, анхдагч материалыг батлагдсан тарифт үнээр нийтийн хэрэгцээнд үйлчилнэ.

4.1.10. Тайлан, холбогдох материалыг ГБТА-т хүлээлгэн өгсөн мэдэгдлийг үндэслэн ажлын 10 өдөрт багтаан захиалагч болон гүйцэтгэгч талууд гэрээг дүгнэсэн акт үйлдэнэ.

4.1.11. ҮГА-аас тухайн төслийн гэрээ дүгнэсэн акт, сайдын тушаалыг үндэслэн ГСА-ын санхүүжилтийн урьдчилж төлсөн зардлын дансыг хааж ҮГА-ны санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэнэ.

4.1.12. ҮГА нь ГСА гүйцэтгэх гүйцэтгэгчийн санхүүжилтийг зогсоох, төлбөр, торгууль, алдангийг дараах үндэслэлээр гүйцэтгэлийн баталгаанаас барагдуулах арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

4.1.12.а/. ГСА-ын арга, аргачлал зөрчсөн,

4.1.12.б/. Захиалагчтай тохиролцолгүйгээр төсөлд заагаагүй ажил гүйцэтгэсэн,

4.1.12.в./шуурхай хяналтын үед илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй,

4.1.12.г/. актаар оногдуулсан төлбөр, торгуулийг барагдуулаагүй,

4.1.12.д/. төсөл хэрэгжүүлэх явцад олж авсан ашигт малтмалын ач холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулсан, бусдад дамжуулсан,

4.1.12.е/.төсөл дээр ажиллаж байгаа голлох мэргэжилтэн (төслийн ахлагч, ахлах геологич)-г захиалагчид мэдэгдэлгүй өөрчилсөн,

4.1.12.ё/.ГСА-ын үр дүнгийн тайланг геологийн даалгаварт заасан хугацаанд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ирүүлээгүй,

4.1.12.ж/.ГСА-ын үр дүнгийн тайланг ГБТА-д хүлээлгэн өгөөгүй.

4.1.12.з/ГСА-ын гэрээ дүгнэсэн актыг заасан хугацаанд үйлдээгүй

4.1.13. Гүйцэтгэгч нь энэ журмын 4.1.2-д заасан хугацаанд ГСА-ыг гүйцэтгэж дуусгалгүй улмаар хугацаа хэтрүүлэн, үр дүнгийн тайланг ЭБМЗ-д хүргүүлсэн тохиолдолд ҮГА нь хоцорсон хоног тутамд төсөлд зарцуулсан нийт төсөвт өртгийн 0.03%-тай тэнцүү хэмжээний алдангийг ногдуулж, ГСА-ын гэрээ дүгнэсэн актад тодорхой заалт оруулан шийдвэрлэж, хэрэгжилтийг хангана.

4.1.14. ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцээд засвар, өөрчлөлт хийлгэхээр буцаан шийдвэрлэсэн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хоног тутамд энэ журмын 4.1.14- д заасан алдангийг мөн адил тооцно.

4.1.15, ҮГА нь геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэсэн акт болон 12 дугаар хавсралтын дагуу үйлдсэн төсвийн нэгтгэлийн хамт яамны холбогдох нэгжүүдэд тухай бүр хүргүүлнэ.

4.1.16. ГСА-ыг өөрийн санаачилгаар дур мэдэн зогсоосон, олгосон, санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан, арга аргачлалын алдаа гаргасан, хангалтгүй гүйцэтгэсэн, ажлын үр дүнгийн тайланг зохиож ЭБМЗ-өөр хамгаалаагүй, тайланг үрэгдүүлсэн тохиолдолд уг төсөлд Улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг гүйцэтгэгчээр эргүүлэн төлүүлэх, 3 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх саналыг ҮГА холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) ..... (төслийн нэр)  
төслийн 20 ... оны төсвийн тодотголын төсөл

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Биет хэмжээ	Төсөвт өртөг
0	1	2	3	4	5
1					
2					
...					
Нийт					

Танилцсан:

... компанийн захирал  
/тамга/

Хянасан:

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

Боловсруулсан:

... төслийн ахлагч

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 3 дугаар хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) ..... (төслийн нэр)  
төслийн 20 ... оны ажлын арга, аргачлал, хэмжээ, төсвийн тодотгол

Гүйцэтгэгч ..... ХХК

Гэрээний дүн: ..... төгрөг

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Гэрээний дүн		20... оны төлөвлөгөө		20... оны гүйцэтгэл		Зөрүү		...		20... оны төсвийн тодотгол		Зөрүү		Гэрээний дүнгийн үлдэгдэл	
				Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	...	...	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	...	...	...	...	...	...	...	...
1																			
2																			
3																			
...																			
Нийт төсвийн дүн																			

Гүйцэтгэгч:

... компанийн захирал  
/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч  
... төслийн ахлагч

Танилцсан:

... ҮГА-ны дарга  
... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга  
... ҮГА-ны асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах нягтлан бодогч  
... ҮГА-ны санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх  
геологийн судалгааны ажлын 20... оны төсөв

/төгрөгөөр/

№	Төслийн нэр	Эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилтийн дүн	20... онд олгох төсөв
0	1	2	3	4	5
1					
2					
...					
Нийт					

Танилцсан:

... ТЗТБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Боловсруулсан:

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 5 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх  
геологийн судалгааны ажлын 20... оны төлөвлөгөө

№	Төслийн нэр, байршил, хавтгайн дугаар	Код	Эхлэх, дуусах хугацаа	Тухайн онд гүйцэтгэх ажил
0	1	2	3	4
1				
2				
...				

Танилцсан:

... ТЗТБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Боловсруулсан:

... ТЗБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 6 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ..... (төслийн нэр)  
төслийн ажлын гүйцэтгэл

20... оны ... дугаар сарын 01-ээс ... дугаар сарын 30-ны өдөр хүртэл

Гэрээний дүн: ..... төгрөг

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тухайн жилийн ажлын хэмжээ		Тайлант сарын гүйцэтгэл		Оны эхнээс гарсан гүйцэтгэл	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	1	2	3	4	5	6	7	8	
1									
...									
Нийт									

Гүйцэтгэгч:

... компанийн захирал

/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

... төслийн ахлагч

Танилцсан:

... ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

... ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Геологийн судалгааны ажлын 20... оны гүйцэтгэл, зардлын тайлан

Төслийн нэр: .....

Гэрээний дугаар : .....

Гэрээний дүн: .....  
төгрөг

№	Ажлын нэр төрөл	Цалин	НДШ	Материалын зардал	Бичиг хэрэг	Сэлбэг хэрэгсэл	Томилголт	Ашиглалтын зардал	Түрээсийн зардал	Түлш шатахуун	Үндсэн хөрөнгийн элэгдэл	Тээврийн зардал	Хээрийн нэмэгдэл	Холбоо	Татвар	Гадны байгууллагын зардал	Бусад зардал	...	Нийт зардлын дүн	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	...	...	
1	Төсөл, төсөв зохиолт																			
2	АГС-ын тайлалт																			
3	Зураглал																			
4	Эрлийн маршрут																			
5	Талбайн сорьцлолт																			
6	Геохимийн судалгаа																			
7	Гидрогеологийн судалгаа																			
8	Геоморфологийн судалгаа																			
9	Геофизикийн судалгаа																			
10	Топогеодезийн судалгаа																			
11	Уулын ажил																			
12	Өрөмдлөгийн судалгаа																			
13	Сорьцлолт																			
14	Лабораторийн шинжилгээ																			
15	Суурин боловсруулалт																			
...	...																			
Нийт дүн																				

Гүйцэтгэгч:

... компанийн захирал  
/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч  
... төслийн ахлагч

Улсын төсвийн хөрөнгөөр 20... онд гүйцэтгэх геологийн судалгааны  
ажлын санхүүжилтийн хуваарь

Гэрээний дүн: .....  
20 ... онд батлагдсан дүн: .....

/төгрөгөөр/

№	Төслийн нэр	20... онд батлагдсан төсөв	Олгох хэмжээ /сараар/											
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
0														
1														
2														
...														
Нийт														

Танилцсан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Боловсруулсан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн нягтлан бодогч

... ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 9 дүгээр хавсралт

БАТЛАВ: ..... ҮГА-ны дарга

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын  
20... оны ... дугаар сарын гүйцэтгэлийн нэгтгэл

Огноо

/Төгрөгөөр/

№	Төслийн нэр	Эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Өмнөх оны жилийн эцсийн гүйцэтгэл	20... оны төлөвлөгөө	Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажил	Хянасан
0	1	2	3	4	5	6	7
1							
...							
Нийт							

Танилцсан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах нягтлан бодогч

Хянасан:

... ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Нэгтгэн боловсруулсан:

... ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 10 дугаар хавсралт

20... онд шинээр эхлэх төслүүдийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Төслийн нэр	Код	Талбайн хэмжээ /кв.км/	Байршил	Хавтгайн дугаар	Хэрэгжих хугацаа	Төсөв өртөг	20... онд санхүүжих дүн	Нэгж өртөг тооцсон үндэслэл
0	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									
...									

Танилцсан:

ҮГА-ны дарга

Хянасан:

ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Боловсруулсан:

ҮГА-ны геологийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 11 дүгээр хавсралт

Геологийн мэдээллийн баримтын архивт тайлан, материал хүлээн авсан тухай  
мэдэгдэл

1. Тайлангийн нэр, хувийн дугаар: .....
2. Талбайн байршил: .....
3. Судалгааны төрөл, үе шат: .....
4. Тайлан зохиогч: .....
5. Геологийн даалгаврын хугацаа: ..... /он.сар.өдөр/  
Эхэлсэн: .....  
Дууссан: .....  
Өөрчилсөн: .....

6. Төслөөр гүйцэтгэсэн үндсэн ажил:

№	Гүйцэтгэсэн ажил	Хэмжих нэгж	Төсөл		Санхүүжилт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
0	1	2	3	4	5	6
1						
2						
...						
Нийт						

7. Тайлан хамгаалсан хугацаа:  
Геологийн нэгжил ирүүлсэн: .....  
ЭБМЗ-өөр хэлэлцсэн: .....  
ГМТ-д хүлээлгэн өгсөн: .....

8. Тэмдэглэл: "....."  
(ГМТ-д хүлээлгэн өгсөн тайлангийн боть, хувь, хавсралт зураг, бичвэрийн  
дискийн тоо, хээрийн судалгааны анхдагч материал хүлээн авсан актын дугаар  
зэргийг тэмдэглэнэ)

Тайлан хүлээн авсан:

Тайлан хүлээлгэн өгсөн:

Геологийн мэдээллийн төв  
архивын дарга

..... ХХК-ийн захирал

(тэмдэг)

(тамга)

Геологийн мэдээллийн төв  
архивын мэргэжилтэн

Ерөнхий геологич/Төслийн  
ахлагч

Огноо

Огноо

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 20... оны  
... дугаар тушаалын 12 дугаар хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) ..... (төслийн нэр)  
төслийн 20 ... - 20... онд гүйцэтгэсэн ажлын төсвийн нэгтгэл

Гүйцэтгэгч ..... ХХК

Гэрээний дүн: ..... төгрөг

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Гэрээний дүн		20... оны гүйцэтгэл		20... оны гүйцэтгэл		...		Нийт гүйцэтгэл		Илүү, дутуу хийгдсэн ажлын зөрүү	
				Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	...	...	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг
0	1	2	3	4	5	6	7	10	11	...	...	...	...		
1															
2															
3															
...															
Нийт төсвийн дүн															

Гүйцэтгэгч:

... компанийн захирал  
/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

... төслийн ахлагч

Танилцсан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ҮГА-ны геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ҮГА-ны захиргаа, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах нягтлан бодогч

... ҮГА-ны геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

